

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Норов	Дугаар	L065
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Хөлөнбуйр сум
Төрсөн газар	Дорнод аймаг Хөлөн буйр сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баргын хийд	Сүм хийдийн дугаар	ДОХБ 002
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

### Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Баргын хийд

-Хөлөнбуйрын хийдийн талаар мэдэх зүйлээ хэлж өгнө үү?

Алтай Хангай уулын цаанаас Баргын хийд нүүдэллэж ирсэн.Ээж Хайрхан уулын тэндээс л. Уулыг нь догшин уул гэдэг байсан. Одоо тэнд Шарга сум бий.

-Тэгээд тэр хийд маань явсаар Хөлөнбуйрт ирсэн үү?

Тийм.

1943 онд зүүнтшээ Баргад сайн цагийн 1000 бурхан гээд Дүйнхор лойдорыг хийж дуусгасан. Тэрийгээ Баргийн хийдэд залахаар явсан. Баянхонгор, Говь-Алтай хоёрын дунд нэг сайхан хийд байсан юм. Тэрнийг сэргээсэн болов уу?

-Алтай хангайн Баргийн хуучин хийдийн охиноо яасан гэлээ?

Охиноо хүнд өгөөд нүүсэн гэнэ лээ.

-Тэр хийдтэй ямар холбоотой юм бэ?

Бид тэр хийдэд нэг зун зуншаад бурханаа аваад зүүнтэш нүүсэн. Одоогийн Ганданд байгаа Махагал чинь л тэр үеийн Махагал байгаа. Тэгээд тэрийг чинь нандин шүтээн гээд хаа яагүй шүтэж байдаг.

-Тэр Алтай Хангайн өмнөх хийдийн нэрийг юу гэдэг байсан бэ?

Хийдийг ламын нэрээр нэрлэсэн байсан.

-Тэр зохиосон дуу ямар учиртай юм бэ? Хийдтэйгээ ямар холбоотой юм бэ?

Бурхан сахиусаа аваад нүүсэн юм. Нүүгээд явж байхдаа Баянхааны баруун урагш Хөхүүртийн талд нэг хэсэг байсан. Хаацаар бүрсэн модон хөхүүр гэж байдаг юм. Тэрийгээ орхиод нүүгээд явсан болохоор Хөхүүртийн тал болсон. Одоо тэр нь Хүүртийн тал гэж яригдаж байгаа юм. Тэгж явахдаа Норовлингийн наад талын Түмэнхаан ууланд хурал цуглаан хийдэг байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тэр эмэгтэй нь юу гэж дуулсан гэлээ?

Алтай хангайн даваанд атан тэмээ жа жа

Аавыгаа л гэж бодохоор алаг нүдэн нулимастай

Ихтэй Хангайн даваанд ингэн тэмээ жа жа

Эжийгээ л гэж бодохоор эрэвгэр нүдэн нулимастай